

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 2 сарын 9 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

## НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.10 дахь заалт, Ногдол ашгийн журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдэд 2023 оны цэвэр ашгаас 3,3 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилсугай.
2. Нэгж хувьцаанд 2 төгрөг 19 мөнгөний ногдол ашиг тараахаар тогтоосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр, ногдол ашиг төлөх сүүлийн өдрийг 2024 оны 4 сарын 30-ны өдрөөр тус тус тогтоосугай.
4. Ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, жижиг хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”ХХК-р дамжуулан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг компанийн данснаас хувьцаа эзэмшигчдийн дансанд олгосугай.
5. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал /Ж.Ганхүлэг/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,  Ч.ЧИНЗОРИГ



# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 2 сарын 9 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 64 дүгээр зүйлийн 64.2, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 3 сарын 23-ны өдрийн 10:00 цагт компанийн ажлын байр /Баянгол дүүргийн 2-р хороо Эрхи төвийн 402 тоот/-д хуралдуулсугай.
- ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
  - Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
  - Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;
  - “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
  - Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах тухай хэлэлцэн батлах
  - Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргахтай холбогдуулан Тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг хэлэлцэн батлах
  - Компанийн зарласан хувьцааны тоог нэмэх тухай хэлэлцэн батлах
  - Компанийн шинэчилсэн дүрэм батлах
  - Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах;
  - Бусад
- Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 3 дугаар сарын 4-ний өдрөөр тогтоосугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт №1, “Хурлын дэг”-ийг Хавсралт №2, хувьцаа эзэмшигчдээс авах “Саналын хуудас”-ыг Хавсралт №3, “Хурлын зар”-ыг Хавсралт №4-р тус тус баталсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахтай холбогдуулан доорх бичиг баримттай 2024 оны 3 сарын 18-ны өдрөөс 2024 оны 3 сарын 22-ны өдрийн 17:00 цаг хүртэл компанийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурдсугай. Үүнд:
  - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол болон тус тогтоолд холбогдох хавсралтуудын хуулбарууд,

2. Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн хуулбар

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт 2024 оны 2 сарын 14-ний дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэх, Хавсралт №4-ийн дагуу хурлын зарыг 2024 оны 2 сарын 16-ны дотор Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолын 3.6-д заасны дагуу Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д цахим хуудсаар тус тус дамжуулан нийтэд мэдээлэх, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолын 3.3, 3.4-д заасны дагуу 2024 оны 2 сарын 21 болон 2024 оны 3 сарын 7-ны өдөр тус тус өдөр тутмын 2-оос доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз мэдээллэх, 2024 оны 2 сарын 19-ны дотор брокер дилерийн компанид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бадамцэцэгт даалгасугай.
7. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2024 оны 3 сарын 21-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.
8. Компанийн ээлжит хурлыг удирдан зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн дарга Ч.Чинзориг, комиссын гишүүнээр Ч.Тэмүдэр, хурлын нарийн бичгийн даргаар Б.Бадамцэцэг нарыг тус тус томилсугай.
9. Хурлын тооллогын комиссын даргаар М.Уянга, тооллогын комиссын гишүүнээр И.Алтанцэцэг, Т.Батчимэг нарыг тус тус томилсугай.
10. Хурлын бэлтгэлийг хууль, журмын дагуу сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн  
2024 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн  
2 тоот тогтоолын Хавсралт №1



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК
Хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо Эрхи төв 4-402 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2024 оны 3 сарын 23 өдөр 10:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Компанийн ажлын байр
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2024 оны 2 сарын 9 өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2024 оны 2 сарын 14 өдөр
Бүртгэлийн өдөр:	2024 оны 3 сарын 04 өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2024 оны 2 сарын 19 өдөр
Хүргүүлсэн огноо:	2024 оны 2 сарын 14 өдөр
Саналын хуудас хүлээн авах сүүлийн өдөр	2024 оны 3 сарын 21 өдөр 17 цаг хүртэл
Хурлын даргын нэр:	Ч.Чинзориг
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	М.Уянга, И.Алтанцэцэг, Т.Батчимэг
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
Баримт бичгийн хуудасны тоо:	ширхэг ...
	хуудас ...

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

/Ч.Чинзориг/

2024 оны 2 сарын 9 өдөр



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн  
2024 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн  
2 тоот тогтоолын Хавсралт №2



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1	Бүртгэлийн үйл ажиллагаа	10 минут	Тооллогын комисс
2	Хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах	5 минут	Хурлын дарга
3	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;	5 минут	Гүйцэтгэх захирал
4	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;	5 минут	Аудитын хорооны дарга
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын №2 “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолыг танилцуулах;	5 минут	Хурлын дарга
6	Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах тухай хэлэлцэн батлах	10 минут	Хурлын дарга
7	Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргаж байгаатай холбогдуулан Тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг хэлэлцэн батлах	5 минут	Хурлын дарга
8	Компанийн зарласан хувьцааны тоог нэмэх тухай хэлэлцэн батлах	10 минут	Хурлын дарга
9	Компанийн шинэчилсэн дүрэм батлах	10 минут	Хурлын дарга
10	Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах	10 минут	Хурлын дарга
11	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах	5 минут	Гүйцэтгэх захирал
12	Бусад асуудлыг хэлэлцэх	10 минут	Хурлын дарга
13	Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт	20 минут	Хурлын дарга,
14	Саналын хуудсаар санал авах	10 минут	Тооллогын комисс
15	Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх	30 минут	Тооллогын комисс
16	Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тогтоолыг батлуулах	10 минут	Хурлын дарга
	Хурлын үргэлжлэх хугацаа	2 цаг 40 минут	

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн  
2024 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн  
2 тоот тогтоолын Хавсралт №3



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Компанийн оноосон нэр: ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК  
Байршил: Компанийн ажлын байр  
Хурал хуралдах огноо: 2024 оны 3 сарын 23-ны өдөр 10:00 цагт

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:				
Итгэмжлэлийн дагуу төлөөлж байгаа төлөөлөгч этгээдийн тухай тайлбар:				
Регистрийн дугаар:				
Санал өгөх хувьцааны тоо:				
Утасны дугаар:				
Цахим хаяг:				
Хэлэлцэх асуудал		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай			
2	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;			
3	Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах тухай хэлэлцэн батлах			
4	Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргаж байгаатай холбогдуулан тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг хэлэлцэн батлах			
5	Компанийн зарласан хувьцааны тоог нэмэх тухай хэлэлцэн батлах			
6	Компанийн шинэчилсэн дүрэм батлах			
7	Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах			
8	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах;			
9	Бусад			

Заавар: Та өөрийн саналыг (+) тэмдгээр бичнэ.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг : ..... /  
Тооллогын комисс бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм  Үгүй   
Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл: .....

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн  
2024 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн  
2 тоот тогтоолын Хавсралт №4



ТАНДЕМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Хурлын төрөл:	Ээлжит
Хурал хуралдах өдөр, цаг:	2024 оны 3 сарын 23 өдөр 10:00 цагт
Хурал хуралдах газар	Баянгол дүүрэг 2-р хороо Эрхи төв 402 тоот
Бүртгэлийн өдөр:	2024 оны 3 сарын 04 өдөр
Хэлэлцэх асуудал:	<ol style="list-style-type: none"><li>1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;</li><li>2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;</li><li>3. “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;</li><li>4. Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах тухай хэлэлцэн батлах</li><li>5. Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргаж байгаатай холбогдуулан Тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг хэлэлцэн батлах</li><li>6. Компанийн зарласан хувьцааны тоог нэмэх тухай хэлэлцэн батлах</li><li>7. Компанийн шинэчилсэн дүрэм батлах</li><li>8. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах</li><li>9. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах;</li><li>10. Бусад</li></ol>
Баримт бичигтэй танилцах:	2024 оны 3 сарын 18-ны өдрөөс 2024 оны 3 сарын 22-ны өдрийн 17:00 цаг хүртэл
Холбоо барих:	info@vik.mn tandeminvest.nbf@gmail.com 70151510, 94002977